



МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан.

Дэлхий даяар хурдтай хөгжиж байгаа цахим технологийг ашиглан төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шуурхай, хялбар хүргэх, хуулийн хүрээнд мэдээлэл хайх, хүлээн авах, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд хооронд мэдээлэл солилцох орчныг бүрдүүлж нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх үүднээс Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна:

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсгийг “... иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй ...” гэж өөрчлөн найруулсан билээ.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар,

эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.” гэж заажээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2005 оны 60/21 дүгээр тогтоолоор баталсан “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-ыг Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр соёрхон баталсан бөгөөд тус конвенцид “..этгээдүүд хоорондын харилцаанд цахим болон цаасан суурьтай мэдээллийн эрх зүйн ижил тэнцүү чадамжтай байдлыг хангах, цахим хэлбэрээр үйлдсэн гэсэн үндэслэлээр аливаа харилцааны хууль зүйн хүчинтэй байдлыг үгүйсгэхгүй байх, цахим харилцааны баримт бичгийг илгээх, хүлээн авах цаг хугацаа, оршин байгаа газрыг тодорхойлох” гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1-д “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.” гэж, 4.1.1-д “Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.” гэж, 4.1.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.” гэж, 4.4.11-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний ... мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна.” гэж, мөн 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дахь заалтын 1 дүгээр үе шат(2021-2030)-ны 4-т “Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна.” гэж, 5-д “Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдэж, мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ.” гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.2.2-т “Төрийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд үнэн, бодитой, цаг үеэ олсон, шаардлагатай мэдээллийг төрийн мэдээллийн санд төвлөрүүлж, эрх бүхий этгээд хамтран ашиглах, солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 3.6.2.3-т “Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.” гэж, 3.6.3.3-т “Төрийн өгөгдөл мэдээллийг ангилж, үнэ цэнийг тогтоох, бүртгэх, хадгалах, дамжуулах, шилжүүлэх, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож мөрдөнө.” гэж, 3.6.4.1-д “Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.” гэж, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.7-д “авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих” гэж, 2.1.8-д “иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах...” гэж, 3.1.3-т “ил тод, нээлттэй байх

зарчим: Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, иргэн, хуулийн этгээд хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэж, 4.1.1.9-д “төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах” гэж, “Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2018 оны 54 дүгээр тогтоолын 2-т “төрийн мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, өгөгдөл хамгаалах, цахим засгийг бэхжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой арга хэмжээг судалж танилцуулах” гэж тус тус заажээ.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийг ил тод байлгах асуудлыг, Шилэн дансны тухай хуулиар төрийн байгууллагуудын төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, тэдгээртэй холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байх харилцааг зохицуулсан.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хууль нь дээр дурдсан хүрээнд мэдээллийг ил тод, нээлттэй хүргэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч хэрэгжилтийн хувьд учир дутагдалтай буюу хуулийг агуулгын хувьд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн дүгнэлтүүд гарсаар байна. Тухайлбал, IRIM буюу Хараат бус судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын тухай” судалгааны тайлан, Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр “Глоб Интернэшнл төв”, “Зориг сан” зэрэг төрийн бус байгууллагуудын хамтран гүйцэтгэсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн хуулийн хэрэгжилтийн тайланг дурдаж болох юм.

Ил тод байх мэдээллийн талаар хангалттай зохицуулалт байхгүйгээс төрийн байгууллагууд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг “албаны нууц”-д хамааруулан тогтоох боломжтой байгаа нь иргэний Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрх хөндөгдөхөд хүрч байна.

Мөн ил тод мэдээллийн болон нээлттэй өгөгдлийн сан бий болгож, улмаар иргэн, хуулийн этгээд төрөөс бий болгосон нээлттэй өгөгдлийг өөрийн бизнес, үйлдвэрлэл, техник технологи, мэдлэгийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр бий болгохдоо ашиглах боломжийг нээх шаардлага мэдээллийн технологийн салбарын өнөөгийн хөгжлийн түвшин, дэлхий нийтийн жишиг, хандлагын дагуу урган гарч байна.

Төрийн байгууллагад цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа мэдээлэлд суурилан төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, төрийн байгууллагууд хоорондоо цахимаар мэдээлэл солилцох эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага бий болоод байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас төрийн цахим харилцаа, цахим засгийг хөгжүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд тодорхой шийдвэрүүд гаргаж томоохон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд төрийн байгууллагууд

өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй технологийн тусламжтайгаар, үр ашигтай харилцах, үйлчилгээгээ хүргэх цахим орчны дэд бүтэц, техник, технологийн суурь, дундын нөөцийг алхам алхмаар бүрдүүлж байна.

Цахим орчны дэд бүтэц, техник, технологийн суурь, дундын нөөц бүрдэж буй энэ үед төрийн байгууллагууд жигд, тэгш оролцоотойгоор, харилцан уялдаатай ажиллаж, үүндээ тулгуурлан аливаа этгээдэд мэдээлэл, үйлчилгээг цахим хэлбэрээр шуурхай, хялбар байдлаар хүргэх, өөр хоорондоо мэдээлэл дамжуулах, хүн бүр хуулийн хүрээнд мэдээлэл эрэх хайх, олж авах орчин бүрдүүлэхтэй холбогдох харилцааг хуульчлах шаардлагатай байна.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны цахимжилт эрчимжиж, технологи нэвтрүүлэх ажил Засгийн газрын тогтоолоор хэрэгжиж, ахицтай байгаа ч хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн уялдаа сул, мэдээллийн технологийн сонголт, хоорондын нийцэл, санхүү, эдийн засгийн үр ашгийн байдлыг үнэлж, дүгнэх болон мэдээллийн сангийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх ажиллагаа хийгдэхгүй байгаа нь хууль, эрх зүйн орчин дутагдалтай байгаатай холбоотой юм.

Монгол Улсад интернетийн үйлчилгээ 1996 онд, интернет банкны үйлчилгээ 2002 онд тус тус нэвтэрч, төрийн болон бизнесийн олон үйлчилгээ онлайн, цахим хэлбэрээр хийгдэх болсон.

2019 оны жилийн эцсийн байдлаар гар утас хэрэглэгчдийн тоо 4,36 сая, түүний дотор ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 3,1 саяд хүрч, үүрэн холбооны 4 дүгээр үеийн технологи нийт 360 гаруй сум, суурин газруудыг хамраад байгаа нь иргэд, хуулийн этгээдийн зүгээс төрийн үйлчилгээ, мэдээллийг хүндрэл, зардал багатайгаар орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах эрэлт, хэрэгцээг бий болгож байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор баталсан цахим хэлбэрээр үзүүлж болох 496 үйлчилгээний 320 нь буюу 64 хувь нь баримт бичиг, лавлагаа, мэдээллийн бүрдэл шаарддаг бөгөөд тус баримт бичиг, лавлагаа, мэдээлэл нь төрийн бусад байгууллагаас олгогддог байна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 2013 онд явуулсан “Төрийн үйлчилгээг онлайн болгох техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах” зөвлөх үйлчилгээний судалгаанд төрийн нийт үйлчилгээний 55,5 хувь нь төрийн бусад байгууллагад байгаа мэдээлэл, лавлагаа, баримт бичиг авч ирэх шаардлага тавьж байгаа талаар дурджээ. Иргэдэд чирэгдэлтэй энэ байдлыг зогсоохын тулд төрийн байгууллагууд мэдээллээ цахим технологийн тусламжтайгаар харилцан шуурхай солилцох, төр өөрт байгаа мэдээллийг иргэнээс шаардахгүй байх талаар хуульчлах нь зүйтэй юм.

Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гардаг лавлагаа, тодорхойлолт болон бусад цахим баримт бичгийг байгууллагууд хүлээн зөвшөөрөхгүй, шүүх нотлох баримтаар үнэлэхгүй байх зэрэг асуудал гарч байгаа нь иргэдийг ихээхэн бухимдуулж, хуульчдын дунд маргаан дагуулж эргэлзээтэй байдлыг үүсгэж байна.

Иймд цахим баримт бичгийн хүчинтэй байдал, түүний баталгаажилтын талаар хуульчлан тодорхой болгох нь зүйтэй.

Түүнчлэн, Монгол Улсын хэмжээнд өнөөгийн байдлаар мэдээ, мэдээлэл, мэдээллийн сан, цахим системтэй холбоотой зохицуулалт 154 хуулинд тусгагдсан байна. Эдгээрийн ихэнхи хэсэг нь мэдээллийн сан бүрдүүлэх харилцааг л зохицуулж байгаа ба мэдээлэл, мэдээллийн санг үүсгэх, бүрдүүлэх эрх бүхий этгээд, нэгдсэн бүртгэл хяналтад байх зэрэг бусад харилцаа одоог хүртэл хангалттай зохицуулалтгүй байгаа нь ижил мэдээллийн сан хоёр байгууллага дээр давхардан үүсэх, эдгээр мэдээллийн сан дахь мэдээллүүд зөрөх, улмаар иргэн, хуулийн этгээдэд чирэгдэл үүсгэх талтай.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр хуулийн хэрэгжилт нийтлэг зөрчил ихтэй, хуулийн “төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах” гэсэн үндсэн зорилгыг хангахгүй байгаа, төрийн байгууллагын үйл ажиллагааны олон нийтэд хүргэх мэдээллийг заасан зохицуулалтуудын агуулга оновчгүй, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтэд хариу өгөхтэй холбоотой үүсдэг зөрчлийг шийдвэрлэх, хуулийн биелэлтэд хяналт тавих зохицуулалтыг бий болгох, хурдтай хөгжиж буй харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурлан мэдээллийг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх зэрэг үндэслэл шаардлагад нийцүүлж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг шинэчлэн батлах шаардлагатай” гэсэн зөвлөмж гарсан.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтуудыг тусган боловсруулна:

- 1.нийтийн мэдээлэл, түүний ангилал;
- 2.мэдээлэл хариуцагчаас ил тод, нээлттэй байлгах мэдээлэл;
- 3.хязгаарлалттай, хаалттай мэдээлэл, тэдгээртэй холбогдох зохицуулалт;
- 4.нээлттэй өгөгдөл, түүний зохицуулалт;
- 5.цахим хуудастай байх, тус цахим хуудсыг хөтөлж, иргэдийг мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэхэд тавих шаардлага зэрэг цахим хуудас хөтлөхтэй холбоотой харилцаа;
- 6.мэдээлэл хариуцагчийн талаарх зохицуулалт;
- 7.иргэний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор мэдээлэл авах хүсэлт гаргах, мэдээлэл хариуцагч иргэний мэдээлэл авах хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт;
- 8.нийтийн мэдээллийн дэд бүтцийн зохицуулалт, түүний хүрээнд:
 - 1)төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахимаар үзүүлэх эрх зүйн үндэс, боломжийг бүрдүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтэц болох үндсэн(Хур) болон дэмжих систем, тэдгээрт тавих нөхцөл шаардлага, журам, мөн мэдээлэл хариуцагчийн системийн талаархи зохицуулалт;

2)мэдээллийн нэгдсэн сүлжээ, түүний төрөл, тэдгээрийн талаарх зохицуулалт;

3)нийтийн мэдээллийн сангийн ангилал, суурь ба төрөлжсөн мэдээллийн сангийн эрх зүйн байдал, нэгдсэн бүртгэл хөтлөх талаарх зохицуулалт;

4)дэмжих системийн төрөл болох танилт, нэвтрэлтийн систем, нийтийн түлхүүрийн дэд бүтэц, албан бичиг солилцооны дундын систем, цахим шуудангийн систем, мэдээлэл солилцооны бүртгэлийн систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем("e-mongolia"), төлбөр тооцооны систем, нийтийн мэдээллийн систем ашиглан төрийн үйлчилгээ үзүүлэхдээ нийтийн мэдээллийн системд байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх талаар, мөн нийтийн мэдээллийн системээс олгогдох цахим баримт бичгийн хүчинтэй байдал, баталгаажилтын талаарх зохицуулалт;

9.төрийн харилцаа холбоо, мэдээллийн технологийг нэгдсэн удирдлага, төлөвлөлтөөр хөгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд нийтийн мэдээллийн дэд бүтцийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо, бүрэн эрх, чиг үүрэг, оролцогчдын эрх, үүргийн талаарх зохицуулалт зэрэг болно.

Хуулийн төслийн зохицуулалтын агуулгад нийцүүлэн хуулийн нэрийг Нийтийн мэдээллийн тухай гэж өөрчилнө.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх саналын талаар

Төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй болгох, Монгол Улсын Үндсэн хуульд заасан, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах эрх зүйн орчин баталгаатай бүрдэж, төрд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ. Түүнчлэн төрийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал сайжирснаар хүнд суртал, авлига, ашиг сонирхлын аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

Иргэн, хуулийн этгээдийн хувьд төрийн мэдээлэл, үйлчилгээг төрийн байгууллагад биечлэн хандаж авахаас гадна цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахим хэлбэрээр авах боломж бүрдэнэ.

Иргэд төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэж, Үндсэн хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь хангагдахаас гадна төрийн мэдээлэл, үйлчилгээ авахтай холбоотой үүсдэг байсан зардал болон цаг хугацаа нь хэмнэгдэж, төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамж дээшилнэ.

Нээлттэй өгөгдлийн тусламжтай шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, олон нийтийн хүртээл болгох боломж нээгдэнэ.

Төрийн байгууллагуудын хувьд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж үйл ажиллагааны шинэчлэл, инноваци, мэдээллийн систем, тооцоолон бодох техник хэрэгслийн нөөцийн удирдлага, төлөвлөлт сайжирна. Төрийн мэдээллийн сан, системийн төлөвлөлт, үнэ цэнэ, чадавх өсч, хариуцлага, ил тод байдал дээшилнэ.

Монгол Улсын хувьд хөгжлийн олон улсын түвшний үзүүлэлт, тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргадаг засаглалын индекс, цахим засгийн хөгжлийн индекс, Транспаренси байгууллагаас гаргадаг авилгын индекс, Дэлхийн эдийн засгийн форумас гаргадаг өрсөлдөх чадварын индексийн үзүүлэлт сайжирч олон улсад эзлэх байр суурь, нэр хүнд өснө.

Төрийн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулснаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд дахин инженерчлэлийг хэрэгжүүлж, удирдлагын шинэчлэл, мэдээлэлд суурилсан эдийн засгийн шинэ салбар үүсэн хөгжих боломж нэмэгдэнэ.

Төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж дээшилж төрд итгэх итгэл сайжирна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуультай нийцүүлэн боловсруулах бөгөөд Хууль хүчингүй болсонд тооцох тухай болон холбогдох бусад шаардлагатай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---o0o---